



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хавсралтад заасан 49,000,000.00 (дөчин есөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоож Шинжлэх Ухааны Академийн Хими, химийн технологийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Билэгсайхан, Шинжлэх Ухааны Академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000130

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2020 оны 04 дугаар сарын 24 өдрийн
 136 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛ УС" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭИ
 ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ	Ашиглах хугацаа
1	Хьюндай Азера 0213 УНӨ, арал- КНМФН41НВСА136518	2012/2013	ш	1	49,000,000.00	49,000,000.00	0.00	10,000,000.00	3
				1	49,000,000.00	49,000,000.00		10,000,000.00	
	Нийт дүн				(дөчин есөн сая)			(арван сая)	